

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

**ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.12.25

Өлгий сум

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар

- Хөтөлбөр, төлөвлөгөө холбогдох бусад баримт бичгийн хэрэгжилтийг хүргүүлсэн байдал:

1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн газар нь үйл ажиллагааны төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Хууль зүйн сайд, ЦЕГ-ын удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгавар, ажлын чиглэл, биелэлт тооцох хөтөлбөр, төлөвлөгөө, ерөнхийлөгчийн зарлиг, УИХ болон засгийн газрын тогтоол зэрэгт нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллав.

“Цагдаагийн байгууллагаас 2017 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох, баримт бичгийн жагсаалт”-нд орсон баримт бичгүүдийг алба хаагч нарт Цагдаагийн газрын даргын тушаалаар хариуцуулан өгсөн.

Биелэлт, үр дүнг тооцох, баримт бичгийн жагсаалтанд тусгагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж, холбогдох алба, нэгжид хүргүүлэв. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 88 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлигийн 1,3 дахь заалтын биелэлт 100 хувь, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай зарлигийн 1,4 дэх заалтын биелэлт 100 хувь, Монгол Улсын Их хурлын 2016 оны 121 дүгээр тогтоол “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 90 хувь, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 85 хувь, Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоол “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90 хувь, Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 82.6 хувь, Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоол “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт 100 хувь, Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний 2 дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний биелэлт 90 хувь, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоол “Гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төлөвлөгөөний биелэлт 87.1 хувь, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг Цагдаагийн ерөнхий газрын газраас 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт 95.7 хувь, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлт 95.2 хувь, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2014 оны 08 дугаар тогтоол “Засгийн газарт чиглэл өгөх тухай” биелэлт 90.5 хувь, Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоол “Цахим тоглоомын үйл ажиллагааг зохицуулах

журам батлах тухай” тогтоолын 2 дугаар заалтын биелэлт 100 хувь, Засгийн газрын 2013 оны 320 дугаар тогтоол “Монгол Улсын дипломат, албан паспорт буцах, үнэмлэх олгох, эзэмших хадгалах журам” журмын 7.1 дэх заалтын биелэлт 100 хувь, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам батлах тухай” тогтоолын 2 дугаар заалтын биелэлт 91.9 хувь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “2016-2017 оны агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 85 хувьтай биелэлтийг ханган ажилласан болно.

- Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаалын тоо:

1.2. Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөл 2017 онд 28 удаа хуралдаж, 137 асуудал хэлэлцсэн байна.

Энэ хугацаанд Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих стандарт” болон Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тушаалаар шинэчлэгдсэн “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын дагуу Цагдаагийн газрын даргын хүний нөөц, алба хаагч нартай холбоотой Б тушаал 75, үйл ажиллагаатай холбоотой А тушаал 62, нийт 137 тушаал гарсан байна.

- Хүний нөөцийн талаар:

1.3. Цагдаагийн газар нь “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаар тушаалаар төсөвт офицер 67, төсөвт ахлагч 59, гэрээт офицер 4, гэрээт ахлагч 17, төсөвт энгийн 4, нийт 151 орон тоотой ажиллахаар батлагдсан.

Дотоодын цэргийн тухай хууль 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж Монгол Улсын онцгой чухал объектыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй Дотоодын цэргийг дахин байгуулсан бөгөөд Цагааннуур тосгон дахь Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг /гэрээт/-ийг Цагдаагийн газрын бүтэц, орон тооноос хасч “Цагааннуур” чөлөөт бүсийг хамгаалах тусгай салаа /гэрээт/-г салааны захирагч 1, харуулын дарга 3, харуулчин 12, жолооч 1, нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Одоо тус Цагдаагийн газар нь Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх тасаг, Мөрдөн байцаах тасаг, Захиргааны удирдлагын тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Ногооннуур сум дахь Цагдаагийн тасаг, Улаанхус сум дахь Цагдаагийн хэсэг, 12 сум, 1 тосгон дахь хэсгийн төлөөлөгч гэсэн бүтэцтэй, төсөвт офицер 65, төсөвт ахлагч 59, гэрээт ахлагч 4, төсөвт энгийн 4, нийт 132 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн 1, хэсгийн төлөөлөгч 1, нийт 2 орон тоо дутуу бөгөөд томилгооны саналыг холбогдох албанд хүргүүлээд байна.

- Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

1.4. Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланг Цагдаагийн газрын bayan-ulqii.police.gov.mn веб сайт, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар facebook цахим хаягт байршуулж, иргэд олон нийтэд сурталчилсан.

Мөн Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайланг эмхтгэн сэтгүүл гаргадаг ажлыг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар удаа дараа зөрчил заагдаж байгаа бараа, материалын худалдан авалт, үнэт цаасны тайлан, эрүүлжүүлэх болон тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааны хураамжийн төлбөр, тооцоог сар бүр Цагдаагийн даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулдаг ажлыг хэвшил болгосон.

Цагдаагийн газрын гадаад өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор дотоод нөөц бололцоогоо ашиглан шинээр будаж, засварлав.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 34 дүгээр тогтоолоор баталсан **“Иргэдийн нийтийн эргүүл ажиллуулах журам”**-ын хэрэгжилтийг хангах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах зорилгоор иргэдийн нийтийн эргүүлийг 6 удаа зохион байгуулсан.

Эргүүлд 35 байгууллагын 108 алба хаагч хамрагдсан бөгөөд 485 иргэн, албан тушаалтан, 259 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, 95 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 499 хүнд хууль тогтоомжийг сурталчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 267 сэрэмжлүүлэг, зөвлөмж тарааж, 11 зөрчлийг таслан зогсоож, 22 зөрчил илрүүлсэн.

Арга хэмжээг зохион байгуулснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагаанд ахиц гарч, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт буурахад нөлөө үзүүлж байна.

Тус Цагдаагийн газраас төрийн 70, төрийн бус байгууллага 8, аж ахуйн нэгж 9 байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан 3 удаагийн ажил, арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан.

Тус аймгийн хэмжээнд малчдын 82 бүлгэм, 13 өсвөрийн цагдаагийн бүлгэм, 26 хамтарсан баг, 13 сургуульд “Сургуулийн цагдаа” нийт 694 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 13 удаа мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Сумдын Засаг даргын тамгын газрын хууль, эрх зүйн мэргэжилтэн, аймгийн төвийн төрийн байгууллагуудын эрх бүхий алба хаагчдыг оролцуулан **“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах мэргэшүүлэх сургалт, зөвлөгөөн”**-ийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр тус Цагдаагийн газраас зохион байгуулсан.

Сургалтанд хамрагдсан 46 төрийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар мэдээлэл өгч, **“Гэрчилгээ”** гардуулав.

Сургалтанд хамрагдсан төрийн алба хаагчдаар дамжуулан тухайн байгууллагад болон иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд нийт 531 хүнд хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хэрэгжүүлээд байна.

- Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ:

1.5. Тус Цагдаагийн газрын алба хаагч нар “Даваа”, “Баасан” гарагт цуглах үеэр шинээр батлагдан гарсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, бусад эрх

зүйн акт, дээд газраас ирсэн даалгавар, ажлын чиглэлийн талаарх мэдээллийг шуурхай хүргэж, мэдээллийн самбарт байршуулан судлуулж байна.

Мөн зарим хууль, тогтоомжийг файл хэлбэрээр сүлжээнд тавьж алба хаагч нар өөрсдөө бие даан судлах боломжийг бүрдүүлсэн.

Холбогдох эрх зүйн акт болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар тасаг, албадууд дотоодын сургалтаа сар бүр тогтмол явуулж байна.

Цагдаагийн ерөнхий газраас 2017 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд сургалтын төвд зохион байгуулсан шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдээлэл олгох, нутаг дэвсгэрийн иргэд, нутгийн төрийн захиргааны байгууллага, ажилтан, алба хаагчдад сурталчлах зорилготой “Сургагч багш” бэлтгэх сургалтанд 2 алба хаагч хамруулсан.

Сургагч багшаар томилогдсон цагдаагийн хошууч Ж.Өлзийтогтох, Ж.Жанболат нар нийт алба хаагч нарт 16 цагийн сургалт зохион байгуулж, алба хаагч нараас тестээр шалгалт авсан.

Цагдаагийн газар нь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн ОУБ-ын тус аймаг дахь салбартай хамтран шинэчлэгдэн батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар алба хаагч нарт 16 цагийн сургалт явуулсан.

Сургалтаар алба хаагч нарт гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх, хуулийг бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдтэй нийцүүлэн хэрэглэх, мэдлэг ур чадвар олгосон. Сургалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Оюунчимэг, ЦЕГ-ын Сургалт дадлагын төвийн ахлах багш, цагдаагийн хошууч Э.Тэмүүжин нар явуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газраас хамтран 2017 оны 06 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулсан шинээр батлагдан гарсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаарх сургалтанд Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг хамруулсан.

- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай:

1.6. Цагдаагийн алба хаагч нарын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэмт хэрэг болон захиргааны зөрчилд өртөж хохирсон, гэмт хэрэгт холбогдсон алба хаагч нар, тэдний гэр бүлийн гишүүдэд хууль тогтоомжид нийцсэн хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Өлгий сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 35 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мөн хамтран ажилдаг Гаалийн газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Тагнуулын газартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

-Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

1.7. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс Цагдаагийн газрын даргад хандаж 2017 онд 87 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байна. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/99 дүгээр

тушаалаар баталсан “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /код 121/ журам”-ын дагуу хүлээн авч бүртгэн, шийдвэрлэж 100 хувь хариу өгсөн.

Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг товч утгаар нь авч үзвэл ажилд орох, суралцахыг хүссэн 28, ажилд дахин орохыг хүссэн 6, чөлөө хүссэн 13, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 30, тэтгэвэрт гарах, тэтгэмж хүссэн 4, бусад 6 өргөдөл, гомдол байна.

- Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ:

1.8. Цагдаагийн алба хаагч нарын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэмт хэрэг болон захиргааны зөрчилд өртөж хохирсон, гэмт хэрэгт холбогдсон алба хаагч нар, тэдний гэр бүлийн гишүүдэд хууль тогтоомжид нийцсэн хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус Цагдаагийн газраас санаачилсан дээрх ажлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга үүрэг, чиглэл болгосон.

Цэнгэл сум дахь хэсгийн төлөөлөгчөөс сумын удирдлагуудад санал хүргүүлж, хамтран ажилласнаар сумын төвийн замын уулзвар, гудамж талбайд 4.500.000 төгрөгний өртөг бүхий орчин үеийн “TP LINK” маркийн 4 ширхэг хяналтын камерийг суурилуулж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ашиглаж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны улсын төсвөөс Баян-Өлгий аймгийн төв Өлгий сумыг теле камерийн системд холбох, гэртүүлгийн үйл ажиллагаанд зарцуулах 806 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэж, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас “Меротек” ХХК, “Лийдлинк” ХХК -тай 2014 оны 07 дугаар сарын 26-ны өдөр теле камерын систем нийлүүлэх, суурилуулах” тухай 65 тоот гэрээ байгуулан ажилласнаар Өлгий сумын гудамж талбайд 2 км урттай замын дагуу 66 ширхэг гэрэлтүүлэг, 41 цэгт 49 ширхэг хяналтын камер суурилуулах ажил явагдаж, 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Жилд дээрх 66 ширхэг гэрэлтүүлэг, 41 цэгт байрлуулсан 49 ширхэг хяналтын камерийн урсгал зардалд 10 сая төгрөг зарцуулдаг бөгөөд 2017 оны урсгал зардлыг аймгийн ИТХ-д оруулж, шийдвэр гаргуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн газраас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хор уршигийг бууруулах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хүн хүчирхийлэгчийн дэргэд цагдаагийн байгууллагад дуудлага өгч чаддаггүй тул алган дээрээ хар цэг тавин бусдаас тусламж хүсдэг **“ХАР ЦЭГ”** (BLACK DOT) аргыг нэвтрүүлж, иргэд, олон нийтэд сурталчилсан.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг зам тээврийн осолд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор **“Аюулгүй гэрэлтүүлэгч ханцуйвч”** арга хэмжээг нэвтрүүлсэн.

Албан журмын даатгагчдын холбоотой хамтран 600 ширхэг гэрэлтдэг **“Аюулгүй гэрэлтүүлэгч ханцуйвч”**-ийг хийлгэж, аймгийн төвийн бүрэн дунд сургуулийн сурагчдад үнэгүй тараасан.

Судалгаа, дүн шинжилгээ хийсэн ажлын талаар:

1.9. Цагдаагийн газрын судалгаа, дүн шинжилгээний багаас сар бүр аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, иргэдээс хүлээн авсан гомдол, мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж, дүнг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж, цаашид хэрэгжүүлэх ажлаа тодорхойлж байна.

Тухайлбал: Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу ажлын хэсэг Цэнгэл, Баяннуур, Алтанцөгц сумдад “Шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, ажил сайжруулах талаар хэсгийн төлөөлөгч нарт 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаартай зааварчилгааг хүргүүлж, биелэлтийг нь тооцон ажиллав. Үүний үр дүнд дээрх сумуудад зөрчил илрүүлэлт 10-20 хувиар өсч, үйлдэгдсэн гэмт хэрэг 5-15 хувиар буурсан.

Нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг харгалзан аймгийн төвийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг эргүүлийн 6-8 чиглэлд явган болон хөдөлгөөнт хэлбэрээр өдөр, орой, шөнийн хуваариар, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гэрэлтүүлэг муутай гудамж, олон нийтийн бусад газруудад томилон ажиллуулж, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үйл ажиллагаанд тасаг, албадын дарга, чиглэл хариуцсан ахлах байцаагч нар биечлэн болон богино долгионы радио станцаар хяналт тавин ажилласан бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 3831 захиргааны зөрчил илрүүлсэн.

Үйлдэгдсэн зөрчлийг ангилан авч үзвэл танхайрах зөрчил 779, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил 197, жолоодох эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 156 үйлдлийг илрүүлсэн.

Мэдээлэл, нэгтгэн боловсруулах газрын дарга, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очирын өгсөн үүргийн дагуу улирал бүр аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэлд гаргасан загварын дагуу судалгаа, дүн шинжилгээ хийн хүргүүлж байна.

- Бусад

1.10. Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “а”-д заасны дагуу Цагдаагийн газраас 2016 онд хийсэн ажлаа 2017 оны 01 дүгээр сарын 11-нээс 13-ны өдрүүдэд Иргэний зөвлөл болон 13 сум, 1 тосгоны оршин суугчдад тайлагнасан.

Цагдаагийн газрын тайланг иргэд, олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор видео бичлэг хэлбэрээр бэлтгэн хүргэсэн бөгөөд тайлангийн хуралд нийт 1291 хүн оролцов.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гарган оролцож байгаа 2 иргэнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хүндэт өргөмжлөлөөр шагнасан ба хуралд оролцсон иргэдэд цагдаагийн газрын дэргэдэх “Цагаан шонхор” хамтлаг урлагийн тоглолт сонирхуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Цагдаагийн тангараг өргүүлэх тухай” А/29 дүгээр тушаал, Захиргааны удирдлагын газрын даргаас 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 5/03 дугаартай “Ажлын чиглэл”-ийн дагуу Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт цагдаагийн тангараг шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Цагдаагийн газрын алба хаагчдад тангараг өргүүлэх, Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг хүлээн авах ёслолын арга хэмжээг 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 11 цагт аймгийн төв талбайд зохион байгуулав.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Тус цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасаг нь 2017 онд 92 үйлдэлтэй, 228.639.000 төгрөгний хохиролтой, 92 холбогдогчтой 79 гэмт хэргийг илрүүлэн

тогтоож Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс болон Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар шилжүүлэн ажилласан.

ЦБҮАЖ код 307-д заасны дагуу гэмт хэрэг илрүүлэх, тэмцэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэггүй алба хаагчдаас нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг, сэжигтэй этгээдүүдийн талаар сард 2-оос доошгүй мэдээлэл, илтгэх хуудас бичүүлэн авч, эрүүгийн төлөөлөгч нараар шалгуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

“Судалгаа” хэсэгчилсэн арга хэмжээг 3 дугаар сард зохион байгуулж, Өлгий сумын төв мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй 25, Улаанхус сумаас 13, Сагсай сумаас 6, Баяннуур сумаас 7, Цагааннуур тосгоноос 3, Ногооннуур сумаас 11, Булган сумаас 3, Буянт сумаас 6, Алтай сумаас 3, Толбо сумаас 2, Цэнгэл сумаас 3, Алтанцөгц сумаас 2 сэжигтэй этгээд нийт 83 мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдийн судалгааг гаргаж, бүртгэлд хамруулсан.

Тус цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж байсан нийт 2 оргодол, 5 гэмт хэрэгт сэрдэгсэн этгээд байсан бөгөөд тайлангийн хугацаанд олж тогтоон эрэн сурвалжлалтыг нь зогсоон ажилласан. Одоо тус аймагт эрэн сурвалжлагдаж байгаа оргодол, гэмт хэрэгт сэрдэгсэн этгээд байхгүй.

Мөн бусад цагдаагийн газар, хэлтсээс эрэн сурвалжлагдаж байсан 2 оргодол, оршин суугаа газраасаа сураггүй алга болсноор эрэн сурвалжлалт зарлагдсан 20 хүнийг олж тогтоож ажилласан.

2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Мөрдөн байцаах тасаг нь 2017 онд өдөө, аэ аооё í үæ áàéãóëëèààñ äýì ò öýðæéí ø èì æóýé 237 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 120 äì äî è, ì ýäýýéüä ýðççæéí öýðä çñãæ 99 äì äî è, ì ýäýýëëëä ýðççæéí öýðä çñãýöýñ òàðæçàð ñàì àèðàé ì òì éóðì òùí öýì àèðàì ä òçðæçëæ 12 äì äî è, ì ýäýýëëëä òàðüüäëüí äàãóò ø èèæçëæ 1 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг, бусад гомдол, мэдээлэлд нэгтгэн шалгав.

Одоо 5 гомдол мэдээллийг үлдэгдлээр шалгаж байна.

Нийт шалгасан 237 гомдол, мэдээллийн 232 буюу 97.8% хувийг шийдвэрлэсэн.

Ì °í òóãàòàà ä 173 òì éáí ää ä-òì é 120 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 119 холбогдогчтой 87 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 9 холбогдогчтой 31 хэргийг хэрэгсэхгүй болгох саналаар прокурорт, 2 холбогдогчтой 2 хэргийг нэгтгэн шийдвэрлэсэн.

Äýì ò öýðæéí öèì ààñ ó-èðñàì 87.8 сая төгрөгийн хохиролоос 84.9 сая төгрөгийн хохиролыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлэл, эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор 190.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалж ажилласан. Хохриол нөхөн төлүүлэлт 90 хувьтай байна.

2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

ЦЕГ-ын даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 01/441 дугаартай “Үүрэг, ажлын чиглэл”-ийн 2 дахь хэсгийн 2.1.3-д “Хэрэг бүртгэх тасаг нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “5.1 дүгээр зүйл /Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах/-ийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл /Танхайрах/, 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/-ийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйл /Жагсаал цуглаан зохион байгуулах журам зөрчих/-ийн 6 дахь хэсэг, 8.7 дугаар зүйл /Хөрөнгө завших/-д заасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах” гэж харьяалал тогтоож өгсөн бөгөөд мөн даргын 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/189 дүгээр тушаалаар Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйл /Хулгайлах/-ийг хэрэг бүртгэгч шалгах харьяалалтай болсон.

Үүнтэй холбогдуулан хулгайлах зөрчлийг зөвхөн ахлах хэрэг бүртгэгч шалгах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Энэ хугацаанд тус тасаг нь өссөн дүнгээр иргэдээс зөрчлийн 295 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан байна. Үүнээс 72 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 128 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 42 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 40 гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлэн тус тус шийдвэрлэсэн.

Одоо ажиллагаанд 13 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Захиргааны зөрчлийн 72 хэрэг шалгаж, зөрчлийн 46 холбогдогчийг 7.815.000 төгрөгөөр торгож, 22 иргэнийг шүүхээр баривчлуулж, 10 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

Одоо ажиллагаанд 7 зөрчлийн хэрэг шалгагдаж байна.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр эхнэр А.Мартыг зодсон гэх үндэслэлээр зөрчлийн 1713000021 дугаартай хэрэгт шалгагдаж байгаад оршин суугаа газраасаа алга болсон Бохай овогтой Бейвитийг олж, хэргийг шийдвэрлэсэн.

2.4. Замын цагдаагийн албаны чиглэлээр:

Тус цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг нь одоогийн байдлаар 12 хүний бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөнтийн 3 машин, богино долгионы 12 станц, тандагч багаж 7, 7510 маркийн согтуурал хэмжигч багаж-2, бэлэн бус торгуулийн машин-2, тээврийн хэрэгслийг албадан зогсоох зараа-1 ширхэгийг тус тус ашиглаж байна.

НХЖХТ, ОНАБХХ-ийн алба хаагч нараас өдөр бүр 2-3 алба хаагчийг татан авч замын цагдаагийн чиглэлээр ажиллуулж байна.

Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагад замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг сурталчилах талаар ажил зохион байгуулж нийт давхардсан тоогоор 800 гаруй хүнийг хамруулан хууль сурталчлах чиглэлээр яриа, таниулга хийж, энэ талаар аймгийн “НАЗ”, “САЯН”, “ДЕРБЕС” телевиз, радиад ярилцлага өгч, зам тээврийн осол хэрэг, зөрчлийн талаарх тоон мэдээг сар бүр телевиз, радиогоор танилцуулж байгаа болно. Мөн Өлгий сумын нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн осолд дүн шинжилгээ хийж, Өлгий сумын төврүү орж ирж буй улсын чанартай засмал замаар том оврын тээврийн хэрэгслийг оруулахгүй байх, шороон замаар том оврын тээврийн хэрэгслүүдийг явуулах, гарц, тэмдэг тавих талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэл хүргүүлсэнээр Өлгий сумруу улсын чанартай засмал замаар явах том оврын тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг хязгаарлаж байнгын хяналт тавин ажиллаж байна.

Мэдэглэлийн мөрөөр эхний хагас жилээр тэмдэг, тэмдэглэгээ нь унаж, эвдэрсэн замын тэмдэг, тэмдэглэгээг засуулж, нэмж 75 ширхэг тэмдэг, тэмдэглэгээг хийлгэв.

ЗЦТ-аас зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 дүгээр сард “Согтуу” хэсэгчилсэн арга хэмжээ, 2 дугаар сард “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээ,

3 дугаар сард “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж”, “Ачааны авто машин-ачаа тээвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээ, 4 дүгээр сард “Эвдрэл гэмтэл”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж” хэсэгчилсэн арга хэмжээ, “Ачааны автомашин” нэгдсэн арга хэмжээ, “Цэрэг тээвэрлэлт-1” нэгдсэн арга хэмжээ, 5 дугаар сард “Эвдрэл гэмтэл, техинийн байдал”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл” хэсэгчилсэн арга хэмжээ, “Улсын дугаар” нэгдсэн арга хэмжээ “Явган зорчигч”, “Мотоцикол”, “Оюутан тээвэр-1” хэсэгчилсэн арга хэмжээ”, 6 дугаар сард “Ачааны авто машин”, “Эвдрэл

гэмтэл техникийн байдал”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл” хэсэгчилсэн арга хэмжээ тус тус зохион явуулав.

Нийтдээ 14 удаа хэсэгчилсэн арга хэмжээ, 4 удаа нэгдсэн арга хэмжээ зохион явуулсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу аймаг, сум, багийн иргэдийн хурал, Засаг дарга нарын эрх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Хөгжимт драмын театрт **“Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга зам”** сэдэвт зөвлөгөөнийг зохион явуулсан. Зөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын алба хаагчид, тус аймагт үйл ажиллагаа явуулж буй жолооны сургуулиуд, албан журмын даатгагчдын холбоо, иргэдийн төлөөлөл оролцов.

Аймгийн хэмжээнд жолооч бэлтгэх жолооны 9 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жолооны сургуулийн багш нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хичээл заах арга, хэлбэрийг сайжруулах зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр цагдаагийн газарт **“Жолооны сургуулийн багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, зам тээврийн осол, хэргийг бууруулах”** сэдэвт сургалтыг цагдаагийн газарт зохион байгуулав.

Сургалтанд 9 сургуулийн 25 багш хамрагдсан бөгөөд мэдлэг, ур чадвар нь дээшилж, жолооч нарт заах хичээлийн шинэ арга, хэлбэрийг сургалтанд нэвтрүүлж, жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмүүдийг заах үедээ түүнийг биелүүлээгүй улмаас үүсэх хор уршгийг үйлдэгдсэн тодорхой гэмт хэргээс иш татаж заах арга, хэлбэрийг нэвтрүүлж, хамтран ажиллахаар боллоо.

Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадлыг зөв олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг сурталчлах зорилгоор **“Ногоон гэрэл-цагаан шугам”** тэмцээнийг Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургуульд 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав.

Энэ удаа “Ногоон гэрэл цагаан шугам тэмцээн”-ийг Баян-Өлгий аймаг дахь Дэлхийн зөн олон улсын байгууллагын салбар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 9 сургуулийн 45 сурагч, 9 багшийн бүрэлдэхүүнтэй оролцсон.

“Ногоон гэрэл цагаан шугам тэмцээн” тэмцээнийг 5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсанаар онцлогтой болсон бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдлэгтэй болж, замын хөдөлгөөнд соёлтой, аюулгүй оролцох мэдлэгтэй боллоо.

Тус тасгийн алба хаагч нар нийт 2220 зөрчилд 169.439.200 төгрөгийн торгууль оногдуулсан.

Үүнээс эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон гэх 169 иргэнийг 39.840.000 төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэх 208 зөрчил илрүүлж, 31 иргэнийг 7-30 хоногоор баривчлуулж, 177 жолоочийг 06-24 сарын хугацаагаар жолоодох эрхийг хасч, 84.000.000 төгрөгөөр торгосон.

2.5. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасаг нь одоогийн бүтцээр офицер 18, ахлагч 34 нийт 52 алба хаагчийн орон тоотойгоор ажил, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын жижүүрийн шуурхай алба нь 2017 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 1122 тооны гомдол мэдээлэл хүлээн авч бүртгэлд оруулж ажилласан.

Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 109, захиргааны зөрчлийн шинжтэй 927, бусад байдлаар 64 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад адил түвшинд байна.

Эрүүлжүүлэх баривчлах байранд 2017 оны хагас жилийн байдлаар 260 хүн эрүүлжүүлэгдэж, захиргааны журмаар 101 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүлжүүлэгдсэн хүн 15 хүнээр буюу 5.4 хүнээр буурч, баривчлагдсан хүн 71 хүнээр буюу 3.4 дахин өссөн байна.

Энэ хугацаанд эргүүлийн цагдаа нар 524 тооны зөрчил илрүүлэн 393 зөрчилд 3.942.000 төгрөгийн торгууль оногдуулан, 131 тооны зөрчлийг шалгуулахаар холбогдох албан тушаалтанд шилжүүлэн өгч, 47 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны хамгаалалтад үүрэг гүйцэтгэн ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ, сургалт, сурталчилгааг зохион байгуулснаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үед 17 үйлдэгдэж байсан бол энэ оны мөн үед 8 хэргээр буюу 47.0 хувиар буурсан байна.

Харин хүүхэд оролцсон гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 2-оор буюу 66.6 хувиар өссөн байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор аймгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилгээ үзүүлдэг давхардсан тоогоор 2014 иргэн, 272 албан тушаалтан, 1069 аж ахуйн нэгж байгууллагад нэгдсэн хяналт шалгалтыг 20 удаа хийж, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн 232 иргэн, 5 албан тушаалтан, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32.1 дэх заалтыг зөрсөн 150 иргэнд нийт 4.005.000 төгрөгний торгууль оногдуулан, дээрх зөрчлүүдийн улмаас хураагдсан 215.2 литр архи, 347 литр пиво, 14.2 литр дарсыг хурааж хурааж, хууль журмын дагуу шийдвэрлэж ажилласан.

Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архины хор нөлөөг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор Улаанбаатар хотод архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “**АА**” сайн дурын бүлгэмийг санаачлагч 23 хүнийг аймагт урьж, 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр архаг архичид, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, захиргааны журмаар баривчлагдсан 24 хүнийг архинаас татгалзах, соён гэгээрүүлэх яриа таниулгад хамруулсан бөгөөд сургалтанд хамрагдсан 9 хүн архинаас татгалзаж байгаагаа тухайн цуглааны үед илэрхийлсэн.

Тус аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж 264, үйлчилгээний 28 цэг үйл ажиллагаа явуулж, байгаа ба БНКаз Улсаас хууль бусаар оруулж ирсэн архи, дарс ихээр зарагддаг. Зөвшөөрөлгүй цэгт архи согтууруулах ундаа худалдан борлуулах зөрчлийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор энэ чиглэлээр ерөнхий 2, тусгай 7, нийт 9 удаагийн арга хэмжээг 2017 оны эхний хагас жилд зохион байгуулсан.

Эхний хагас жилд согтуугаар 17 тооны гэмт хэрэг үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 буюу 22.7 хувиар буурсан боловч, архидан согтуурч гудамж, талбай, олон нийтийн газарт танхайрах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэх явдал өсөх хандлагатай байна.

Цагдаагийн газраас санаачлан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах иргэн бүрийн хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хууль, эрх зүйн мэдлэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн шинж чанартай “**Хуулиа дээдэлье**” ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаартай захирамжаар “Хуулиа дээдэлье” ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй

байгуулж, ажлын хэсгийн боловсруулсан 27 зүйлтэй төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцэж батасан.

“Хуулиа дээдэлье” ерөнхий арга хэмжээг зохион байгуулснаар иргэд, олон нийтийн хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээ, хариуцлага, хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг оролцоо хангагдан гэмт хэрэг, зөрчлийн суурь шалтгаанууд арилна гэж үзэж байна.

Арга хэмжээг аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран аймгийн хэмжээнд бүтэн жилийн турш зохион байгуулна.

Орон нутгийн “Саян” телевизтэй хамтран насанд хүрээгүй хүүхдүүдэд хууль эрх зүйн анхан шатны мэдлэг олгох, хүмүүжил, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “**Хууль бидний амьдралд**” сэдэвт 15 минут 42 секундын теле хичээлийг бэлтгэж, 3 удаагийн давтамжтай сурталчлав.

Теле хичээлийг ахлах ангийн 900 орчим хүүхэд үзэж, сонирхсон тухай судалгааг хэвлэл мэдээллийн байгууллагаас гаргав.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оныг “**Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил**” болгон зарласантай холбогдуулан “Хуулиа дээдэлье” ерөнхий арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын баталсан “Хууль сурталчлах өдөрлөг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр аймгийн төв талбайд Хууль сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт нийт 1100 орчим хүн оролцсон бөгөөд Цагдаагийн газрын 2017 оны эхний 4 сард хийж, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, салбарын хүрээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмыг иргэд, олон нийтэд сурталчилж, нийт 315 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, санамж, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан 23 хүний санал, хүсэлтийг хүлээн авч, 10 төрлийн үйлчилгээ үзүүлэн хэрэгжүүлсэн ажлын талаар гэрэл зургийн болон цагдаагийн байгууллагын техник, тусгай хэрэгслийн үзэсгэлэнг гаргасан.

Тус Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан нөхцлийг арилгуулахаар 108 мэдэгдэл, 89 шаардлага хүргүүлж биелэлтийг 100 хувь хангасан бөгөөд 45 мэдэгдэл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 39 төрлийн 5993 ширхэг гарын авлага, зурагт хуудас, санам, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд тарааж, телевизээр 96 удаа буюу 660 минут, радиогоор 29 удаа буюу 95 минут, цагдаагийн газрын “Facebook”-т 163, www.bayan-ulqii.police.gov.mn сайтанд 145, нийт 308 удаа мэдээ, мэдээлэл байршуулж, нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэж иргэд, олон нийтэд сурталчилж ажиллав.

Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг иргэн, хуулийн этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “**Хишиг өдөр**” арга хэмжээг зохион байгуулав.

Арга хэмжээнд иргэдийн төлөөлөл болох 6 хүн оролцсон бөгөөд тэд эргүүлийн цагдаа, мэдээлэл хүлээн авагч цагдаа, эрүүлжүүлэх, баривчлах байрны жижүүр цагдаагийн үүрэг гүйцэтгүүлэв.

2.6. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр:

Төрийн өндөр дээд зочин төлөөлөгчийн аюулгүй байдлыг хангах, айлчлалын үеийн төлөвлөгөө зураглалыг гарган шаардлагатай тохиолдолд ашиглахад бэлэн болгох, тодотгол хийх ажлыг зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Их хурлын дарга М.Энхболд 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр тус аймагт ажиллах үеэр нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг гаргаж, явах чиглэлд Тагнуулын байгууллагатай хамтран үзлэг, шалгалт явуулж, хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч С.Ганбаатар, Х.Баттулга, М.Энхболд нар тус аймагт 2017 оны 06 дугаар сарын 12, 14, 16-ны өдрүүдэд хүрэлцэн ирж, сонгуулийн сурталчилгаа зохион явуулсан.

Нэр дэвшигчдийг тус аймагт ажиллах үед цагдаагийн байгууллагаас сонгуулийн тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, ТЕГ, ЦЕГ-ын даргын 2014 оны А/Н/10, МН/23 хамтарсан тушаалаар батлагдаж, 2016 оны А/Н/81, Н-1/54 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай харилцан ажиллах журам”-ын дагуу төрийн тусгай хамгаалалтын алба, аймгийн Тагнуулын газартай мэдээ, мэдээлэл солилцож хамтран ажилласан.

Сонгуульд нэр дэвшигчид тус аймагт сурталчилгаа явуулах, сонгогчидтой уулзах уулзалтын хуваарийн дагуу, явах замын маршрутыг тагнуулын байгууллагатай хамтран урьдчилан шалгаж, төлөвлөгөө, зураглал гарган, хөтөч автомашин ажиллуулж, хэв журмын болон замын хамгаалалтыг ямар нэгэн алдаа дутагдалгүйгээр зохион байгуулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрт жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч болзошгүй цэгийн судалгааг гаргаж, жагсаал цуглааны үед дэг журам сахиулах, хууль бус жагсаал цуглааны албадан тараах төлөвлөгөөнд тодотгол хийж, аймгийн Тагнуулын байгууллагатай энэ талаар мэдээ, мэдээлэл солилцон хамтран ажилласан.

Тус хугацаанд аймагт үйл ажиллагаа явуулдаг улс төрийн нам, эвсэл, иргэдээс 2 удаагийн бүртгэлгүй жагсаал цуглааныг зохион байгуулсан. Үүнд:

- Цэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлаар Ж.Алиман гэгчийг томилсон явдлыг тус сургуулийн багш, ажилчид эсэргүүцэж, томилгоогоо өөрчлөх талаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан шаардлагынхаа хариуг авахаар 2017 оны 05 дугаар сарын 13-ны өдөр тус сургуулийн нэр бүрий 24 багш, ажилчин аймгийн төв рүү ирж, Засаг дарга А.Галымханыг Улаанбаатар хот руу албан ажлаар явахаар аймгийн Нисэх онгоцны буудалд ирэх үед нь уриа, лоозон барин жагсаж, шаардлагынхаа хариуг нэхсэн асуудал гарсан.

Уг жагсаал, цуглааны талаар мэдээллийг хүлээн авсан даруй хүрэлцэн очиж, жагсагчдыг тараасан ба уг үйлдэл нь Жагсаал цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалтыг зөрчсөн тул Цагдаагийн газраас материалжуулан шалгаж, 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан харицлага хүлээлгэхээр шүүхэд шилжүүлэн шүүхээс 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр нэр бүхий 24 иргэнийг тус бүр 20.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

-Тус аймгийн Ардчилсан намын хорооноос аймаг, сумдад үүсээд буй иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх, төрийн албанаас үзэл бодлоор нь хоморголон халах, хавчин гадуурхаж байгаа асуудлаар аймгийн удирдлагад шаардлага хүргүүлэх, хүргүүлж буй шаардлагын агуулгыг олон нийтэд хүргэх, иргэдийн санал бодлыг сонсох зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10 цагаас 12 цагийн хооронд бүртгэлгүй жагсаал, цуглааныг зохион байгуулсан.

Уг жагсаал цуглаан нь Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасныг зөрчиж бүртгэлгүй жагсаал, цуглаан зохион байгуулсан зөрчлийг захиргааны зөрчлийн тоо бүртгэлд оруулан, материалжуулан шалгаж, 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдөр шүүхэд шилжүүлсэн ба шүүхээс жагсаал цуглааныг зохион байгуулагч ардчилсан намын дарга Е.Зангар, А.Байганат нарт Жагсаал цуглаан хийх

тухай хуулийн 15 дугаар зүйлийн 8-д зааснаар тус бүр 20.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

- Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

3.1. Тус Цагдаагийн газрын алба хаагч нараас гаргасан алдаа дутагдал, сахилга ёс зүйн зөрчлийг хамт олноороо хэлэлцэх, дүгнэлт өгөх, цаашид зохион байгуулах ажил, арга хэмжээг тодорхойлох, алба хаагч нарын санал, хүсэлтийг сонсох зорилгоор улирал бүр сахилга, хариуцлагын зөвлөгөөн зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улирлын сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр, 2 дугаар улирлын сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, 3 дугаар улирлын сахилгын зөвлөгөөнийг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, 4 дүгээр улирлын сахилгын зөвлөгөөнийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

Сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр Цагдаагийн газрын даргын зөвлөмж 1, үүрэг, ажлын чиглэл 1, зааварчилгаа 2-ыг бичиж холбогдох албан тушаалтанд өгч, биелэлтийг нь тухай бүр тооцон ажилласан.

Цагдаагийн газрын удирдлагын зүгээс алба хаагч нарт хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, нууцын хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг өндөржүүлэх, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 хоног тутам үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон ажиллав.

Алба хаагчдын идэвх оролцоо, санал санаачлагыг өрнүүлэх зорилгоор алба хаагч нэг бүрээс цаашид анхаарах асуудал, сахилга ёс зүйн зөрчил гаргаад байгаа шалтгаан, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, асуулга авч, **“Сахилга, хариуцлагыг сайжруулахад таны оролцоо”** сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлгийг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдөр офицер, ахлагч бүрэлдэхүүний дунд тус тусад нь явуулсан.

”Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд тасаг, хэсэг, алба хаагч нарын дунд “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон, алба хаагч”-ийг шалгаруулах аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.

Мөн алба хаагчдаас сахилга ёс зүй, харилцааны зөрчил гаргахгүй байх талаар бичгээр баталгаа авсан.

Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч нараар хамт олны өмнө амлалт авахуулж, сахилгын шийтгэлийн хор холбогдол, эдийн засгийн хохирлын талаар яриа хийлгэж, бичгээр баталгаа гаргуулж авсан.

Мөн 2 ба түүнээс дээш удаа сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч нарт **“Итгэл, найдварын хуудас”**, сүүлийн 5 жилд сахилгын шийтгэл хүлээгээгүй, ажлын үр дүн сайтай, хамт олны дунд нэр хүндтэй, бусдыгаа манлайлан ажиллаж байгаа алба хаагч нарт **“Талархлын хуудас”** -ыг Цагдаагийн газрын хамт олноос гардуулах ажлыг зохион байгуулсан.

Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар алба хаагч нарын сахилга, хариуцлага сайжирч, сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч нарын тоо 57.1 хувиар буурч, гэмт хэрэгт холбогдсон алба хаагч гараагүй байна.

- Сахилга ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурорын мэдэгдэл, шаардлага:

3.2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар баталсан “Сахилгын шийтгэл ногдуулах /код 914/ журам”-ын

914.5 дахь хэсгийн 914.5.1-д зааснаар Цагдаагийн газрын сахилгын мэдээг сар бүрийн 25-ны дотор холбогдох материалын хамт ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.

Цагдаагийн газрын хэмжээнд 2017 онд сахилга ёс зүйн зөрчил гаргасан 34 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Сахилгын шийтгэл ногдуулсан байдлаар нь авч үзвэл нийт сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийн 27 буюу 79.4 хувьд нь нь цалин бууруулах, 7 алба хаагч буюу 20.5 хувьд нь сануулах сахилгын шийтгэлийг Цагдаагийн газрын даргын тушаалаар ногдуулсан байна.

Сахилгын шийтгэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 зөрчил буюу 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлангийн хугацаанд гэмт хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй.

Прокурорын шаардлагад дурьдагдсан зөрчлийг дахин давтуулахгүй байх талаар Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн даргаас бичгээр зааварчилгаа өгч биелэлтийг нь тооцон ажилласан. Мөн прокурорын шаардлагын мөрөөр алба хаагч нарт “Алдаан дээрээ суралцъя” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, прокурорын шаардлага авсан шалтгаан, дахин дээрх төрлийн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх арга зам, зохион байгуулах ажлын талаар мэтгэлцээн зохион байгуулав.

Зарим прокурорын шаардлагуудад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тогтоолд өөр хэргийн дугаар, зүйл анги тусгасан талаар дурьдагдсан бөгөөд уг зөрчил гарах болсон шалтгаан нөхцөлийг судлахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар байцаан шийтгэх ажиллагааны тогтоол, тэмдэглэл үйлдэхдээ өмнөх хэргийн тогтоолуудыг хуулбарлахдаа хянадаггүй явдал нь дээрх процессийн зөрчил гарах үндэслэл болсон байсан.

Шаардлагын мөрөөр авагдсан арга хэмжээний талаар прокурорын байгууллагад 14 хоногийн хугацаанд хариу хүргүүлэв.

Зөрчил арилгуулахаар прокурорын байгууллагаас ирүүлж буй шаардлага бүрт ач холбогдол өгч, заагдсан зөрчил бүрийг арилган, түүний мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажилласны үрд дүнд прокурорын шаардлагын тоо өсөөгүй, мөн үеийн түвшинд байна.

- Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт:

3.3. Цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, бие бялдрыг хөгжүүлэх, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын ивээл дор “Ахлагч бүрэлдэхүүний сургалт-зөвлөгөөн”-ийг 2017 оны 02 дугаар сарын 13-наас 16-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Сургалт зөвлөгөөний үед ахлагч бүрэлдэхүүний дунд илтгэлийн уралдаан, буудлага, буухиа гүйлт, ширээний теннис, штанг буюу хүндийн өргөлтийн тэмцээнүүдийг зохион явуулав.

Алба хаагч бүр бие биедээ тавих зарчимч шаардлагыг өндөржүүлж, зөрчил дутагдалтай эвлэрэхгүй байх үзэл баримтлалд төлөвшүүлэх, шат дараалсан хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдах бүрэлдэхүүний манлайлалыг дээшлүүлж, идвэхжүүлэх талаар алба хаагч нарт манлайлал, харилцааны чиглэлээр 1 цагийн сургалт явуулсан.

Мөн алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр МУИС-ийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхмийн эрхлэгч, доктор Б.Хишигням, тус тэнхмийн багш докторант С.Нандинцэцэг нарыг урьж, Цагдаагийн газрын нийт алба хаагчдад “Харилцааны соёл” сэдвээр 2 цагийн сургалт зохион явуулсан.

Сахилга, хариуцлагын зөвлөгөөнд сэтгэл зүйч, цагдаагийн ахмад А.Венера сахилгын шийтгэлтэй алба хаагч нартай уулзаж ярилцлага хийсэн дүгнэлтийг алба хаагч нарт танилцуулж, **“Уур бухимдлыг зохицуулах арга зам”** сэдвээр мэдээлэл хийж, зөвлөгөө өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан тус Цагдаагийн газраас алба хаагч нарыг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх, шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдтэй нийцүүлэн хэрэглэх мэдлэг ур чадвар олгох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр алба хаагч нарыг мэргэшүүлэх, хамтарсан багийг чадавхжуулах зорилгоор тус аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагын орон нутаг дахь салбартай хамтарсан сургалт зохион байгуулав.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Оюунчимэг, ЦЕГ-ын Сургалт дадлагын төвийн ахлах багш, цагдаагийн хошууч Э.Тэмүүжин нар 2017 оны 01 дүгээр сарын 30, 31-ний өдрүүдэд “Хамтарсан баг”, цагдаагийн алба хаагч нарт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх” чиглэлээр 16 цагийн сургалт явуулсан.

Алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр МУИС-ийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхмийн эрхлэгч, доктор Б.Хишигням, тус тэнхмийн багш докторант С.Нандинцэцэг нарыг урьж, Цагдаагийн газрын нийт алба хаагчдад “Харилцааны соёл” сэдвээр 2 цагийн сургалт зохион явуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газраас хамтран 2017 оны 06 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулсан шинээр батлагдан гарсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаарх сургалтанд Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг хамруулсан.

Хэсгийн төлөөлөгч нарыг гэмт хэргийг илрүүлэх, арга тактик эзэмшүүлэх, холбогдох хууль тогтоомжоор мэдлэг олгох сургалтыг Цагдаагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу бүсчилсэн хэлбэрээр Дэлүүн суманд 2017 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдөр, Ногооннуур суманд 2017 оны 05 дугаар сарын 10, 11-ний өдөр тус тус 2 удаа зохион байгуулсан.

Орхон аймгийн ерөнхий газрын даргын 2015 оны 57 дугаар тушаалаар баталсан “Сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх журам” /код 118/ болон сургалтын төлөвлөгөөний дагуу 2017 онд давхардсан тоогоор 95 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 8265 алба хаагч хамрагдсан байна.

- Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал:

3.4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу аймаг, сум, багийн иргэдийн хурал, Засаг дарга нарын эрх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Хөгжимт драмын театрт **“Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга зам”** сэдэвт зөвлөгөөнийг зохион явуулсан. Зөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын алба хаагчид, тус аймагт үйл ажиллагаа явуулж буй жолооны сургуулиуд, албан журмын даатгагчдын холбоо, иргэдийн төлөөлөл оролцов.

Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран **“Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг**

боловсронгуй болгоход талуудын оролцоог хангах нь" сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын тамгын газар, Цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтнууд, Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон МАНУТХГХ захиргааны бүх Байгаль орчны хяналтын улсын байцаагчид, Байгаль хамгаалагчид, мэргэжилтэнүүд, Сум дундын ойн ангийн дарга, Харнуур, Ховд голын сав газрын хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтнүүд зэрэг 100 гаруй хүн оролцлоо.

Зөвлөгөөнөөр ажлын хэсэг байгуулагдан зөвлөмж гарган тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар аймгийн Засаг даргад санал хүргүүлэх, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг шийдвэрүүдийг гаргав.

Цагдаагийн газраас санаачлан Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор баталсан "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн хангах зорилгоор Алтанцөгц, Бугат, Баяннуур сумдын удирдлагуудыг хамруулсан "Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нь" сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг Алтанцөгц сумын төвд 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав.

Зөвлөгөөнөөр "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, малчдын бүлгэмийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шаардагдах санхүүжилтийг сумын төсөвт тусгуулах замаар сум бүрт "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан" байгуулахаар шийдвэрлэсэн.

Хуулиа дээдэлье" ерөнхий арга хэмжээний хүрээнд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран "**Малчдын бүлгэмийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь**" сэдэвт малчдын бүлэгийн гишүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Зөвлөгөөнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд хамтран ажиллаж буй малчдын 82 бүлэгийн 242 гишүүнээс төлөөлөл болох 152 гишүүн оролцов.

Уг зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан, Засаг дарга А.Гылымхан, аймгийн Засаг даргын орлогч Ш.Хабыл, А.Камелият, Засаг даргын тамгын газрын дарга Х.Тилеген, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Ерболат нар болон тус Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Батболд, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч Б.Хайырлыс нар оролцон мэдээлэл хийж, малчдын санал, хүсэлтийг сонсов.

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Батболд аймгийн мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал сэдэвт, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч Б.Хайырлыс "Малчдын бүлэг ажиллуулах үлгэрчилсэн дүрэм"-ийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор "**Гэмт хэргийг бууруулах боломж ...**" сэдэвт хэлэлцүүлгийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр аймгийн Иргэний танхимд зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт Өлгий сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, цагдаагийн газрын болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн холбогдох эрх бүхий алба хаагч нар ороцож, гэмт хэргийг бууруулах арга зам, боломж, анхаарах асуудлыг нээлттэй хэлэлцүүлцэв.

Тус цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгоор нийт зөвлөгөөн -5, сургалт -9, хэлэлцүүлэг, уулзалт -2, тэмцээн 5, өдөрлөг 2, нийт 21 ажил, арга хэмжээг тус тус зохион байгуулав.

- Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ:

3.5. Тус Цагдаагийн газрын алба хаагчдын дунд 2017 онд зохион явуулах соён гэгээрүүлэх ажлын 19 заалт бүхий төлөвлөгөө гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэл зүйн болон бусад төрлийн дэмжлэг туслалцааг үзүүлэх, албандаа итгэх итгэл, урам зориг сэргээх, хамт олны дунд нэгдмэл эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор биеийн тамир, спорт, урлаг, мэдээлэл, танин мэдэхүйн олон төрлийн ажил, арга хэмжээ, уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан.

Зохион явуулж буй соён гэгээрүүлэх ажлын талаарх мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон тус Цагдаагийн газрын bayan-ulgii.police.gov.mn веб сайт, [Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар](#) facebook цахим хаягуудаар тогтмол сурталчилав.

Монголын “Цагаан сар”, казак үндэсний “Науырыз” баярын өдрүүдэд Цагдаагийн газарт ажиллаж байгаад цэргийн тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, мэндчилгээ дэвшүүлэх, үндэсний баярын түүхэн уламжлал, онцлог, ач холбогдлын талаар алба хаагч нарт ахмад хүмүүсээр яриа хийлгэх, ёс заншлийг сурталчилах, таниулах арга хэмжээ зохион байгуулав.

Үүнд: Казак түмний “Наурыз”-ын баярыг тохиолдуулан Баян-Өлгий аймагт амьдарч буй Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин цолтой ахмад буурлуудад хүндэтгэл үзүүлэх, ахмад үеэрээ бахархах, залуучууд, ахмад үеийнхний залгамж холбоог бэхжүүлэх, ахмад настанаа хүндэтгэх уламжлалт ёс заншилаа дэлгэрүүлэх зорилгоор “Баатаруудаа одонгоо зүүцгээе” арга хэмжээг 2017 оны 03 дугаар сарын 20-ны өөр зохион байгууллаа.

Арга хэмжээний үеэр ахмадуудын сургаалыг сонсож, дурсгалын зүйл гардуулав.

Мөн Цагдаагийн газраас Монгол цэргийн баяр, казах үндэстний “Наурыз”-ын баярыг тохиолдуулан байгууллагын ахмадуудыг урьж хүндэтгэл үзүүлэн, ахмадуудын санал хүсэлтийг нь сонсож, сэтгэн бодох чадвар, мэдлэгийг нэмэгдүүлэх, ур чадварыг нь хөгжүүлэх зорилгоор ахмадуудын дунд “АХА” тэмцээн зохион байгууллаа.

Эх үрсийн баярыг тохиолдуулан эмэгтэй алба хаагчдыг ОХУ-ын Горны-Алтай хотод 10 хоног аялуулсан.

Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу тус Цагдаагийн газрын алба хаагчдын ар гэрийхэнийг хамруулах алба хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, эрүүл агаарт чөлөөт цагийн зөв зохистой өнгөрүүлэх, шинэ ондоо ажиллах эрч хүчийг нэмэгдүүлэх, гэрийн уур амьсгалыг дээшлүүлэх, гэр бүлдээ зориулах зохистой цагийг бий болгох зорилгоор Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгаас 2017 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Толбо нуурын мөсөн дээр “Мөнгөн өвөл-2017” спортын арга хэмжээг зохион байгуулсан ба уг арга хэмжээнд алба хаагчид, гэр бүлийн хамтаар оролцсон.

Арван долдугаар жарны “Алтан унжлагат” хэмээх гал тахиа жилийн сар шинийн баярыг тохиолдуулан 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Хөгжимт драмын театрт Баян-Өлгий аймаг дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уран бүтээлчидтэй хамтран “Амар мэндийн дуулал”, Монгол цэргийн баярыг тохиолдуулан 2017 оны 03 дугаар 17-ны өдөр

“Амрыг эрье” тоглолтыг тус тус зохион байгуулж алба хаагчдын ар гэрийнхэнд үнэ төлбөргүй сонирхуулав.

Тус Цагдаагийн газрын алба хаагч нар нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эмзэг бүлгийг дэмжих зорилгоор жил бүр “Сайн үйлсийн аян”-ыг зохион байгуулдаг уламжлалын дагуу амьдралын баталгаажих доод түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрх Өлгий сумын 1 дүгээр багийн иргэн М.Сайранбект туслах ажлыг цагдаагийн газраас 2017 оны 1 дүгээр сард санаачлан зохион байгуулав.

Сайн дурын аяны хүрээнд М.Сайранбекийн гэрт засвар хийж, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхээс гадна 2 тонн нүүрс, 1 м3 мод, хүнсэнд нь зориулж 4 хонь, бэлнээр 150.000 төгрөгний сэтгэлийн дэм үзүүлэв. Мөн 2017 оны 09 дүгээр сард Өлгий сумын Засаг даргын тамгын газраас хариуцуулсан амьдралын баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу 3 өрхөд 300.000 төгрөгийн хүнсний зүйлээр тусламж үзүүлсэн.

Мөн “Сайн үйлсийн аян”-д аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулсан бөгөөд Улаан Загалмай нийгэмлэг 200.000 төгрөгний 3 хүний иж бүрэн хувцас, Цахилгаан шугам сүлжээний газар үнэгүй цахилгаан татаж шаардлагатай эд материалын дэмжлэг үзүүллээ.

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигын дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр Цагдаагийн газрын алба хаагч нар аймгийн “Ногоон бүс”, болон Цагдаагийн газрын хашаанд 130 ширхэг мод тарьсан.

“Эх үрсийн элч” дуучин Ноён Бондгор тус аймагт бие даасан тоглолт хийх үеэр “Гэрээ цэвэрлэе аян”-ыг зохион байгуулсан. Тус аянд цагдаагийн газрын хамт олон нэгдэж, “Ховд” голын эрэг орчмын хогийг цэвэрлэсэн.

Тус Цагдаагийн газрын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчилж олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсгийн хамт олны зүгээс 2017 оны 01 дүгээр сарын 24-26-ны өлрүүдэд “Халуун сэтгэлийн” аян зохион байгуулж тус өдрүүдэд томилгоот цагдаагийн алба хаагч нарыг болон цагдаагийн газарт гэрээтэй НИК шатахуун түгээх станцын түгээгчид, хот тохижуулах албаны цэвэрлэгээ арчилгаа хийж буй ажилчид, “School police” үүрэг гүйцэтгэж буй иргэд, тахсины жолооч зэрэг хүмүүст халуун сүүтэй цай, дархалаа дэмжигч витаминаар үйлчилсэн болно.

Цусны нөөц бүрдүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн цусны төвд Цагдаагийн газрын алба хаагч нар 2 литр цус хандивласан.

Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, тэдний хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор Цагдаагийн газрын даргын тушаалаар “Биеийн тамир спорт хамтлаг”-ийг шинээр байгуулсан. Тухайн хамтлаг нь тасаг, албадууд болон сэтгэл зүйчтэй хамтран бие бүрэлдэхүүний дунд өдөр болгон гимнастик хийлгэх ажлыг хэвшүүлсэн.

Нийтдээ Цагдаагийн газраас алба хаагч, иргэдийн дунд 345 удаа соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 12338 алба хаагч, иргэн хамрагдсан байна.

- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байдал:

3.6. Тус Цагдаагийн газрын bayan-ulgii.police.gov.mn цахим хуудас, Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар фэсбүүк-ээр Цагдаагийн газраас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг тухай бүр тогтмол сурталчилж байна.

2017 онд Цагдаагийн газрын bayan-ulgii.police.gov.mn цахим хуудаст 145 мэдээлэл, Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар фэсбүүк-т 163 мэдээлэл тус тус оруулж, нийтдээ 308 удаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд сурталчилсан байна.

Цагдаагийн газрын “Мэдээ, мэдээллийн төв”-өөр дамжуулан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар радиогоор 29 удаа буюу 95 минут, телевизээр 96 удаа буюу 660 минут, сонин хэвлэлээр 15 удаа нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд түгээж ажиллав.

- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

3.7. “Авлигын эсрэг хууль”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг 70 хувьтай ханган ажиллаж байна.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч, ЦЕГ-т 2017 оны 01 дүгээр сард хүргүүлсэн.

Алба хаагч нарыг эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд татгалзаж, уг этгээдийг тодорхойлох, бэлэг өгсөн талаар удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад мэдэгдэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 139-т заасан маягтын дагуу баримтжуулах”, “Аливаа иргэн, хуулийн этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авах, санхүүгийн туслалцаа, авах, хүсэхийг хориглох бөгөөд албан үүрэгт нь холбогдолгүй гуравдагч этгээдээс хандив, тусламж үзүүлэх санал тавьсан тохиолдолд Цагдаагийн төв байгууллагын Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт мэдэгдэж, зөвшөөрөл авна”, “Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд бичгээр мэдэгдэх” талаарх хууль, журмын заалтуудыг тайлбарлаж, хүлээх хариуцлагын талаар сануулсан.

Мөн алба хаагч бүрээс авлигаас ангид байхаар баталгаа гаргуулан авсан.

Цагдаагийн газрын 2017 оны 1, 3 дугаар улирлын нэгдсэн сургалтын үеэр алба хаагч нарт хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Дэнсмаа “Авилгын эсрэг хууль тогтоомж”-оор 2 удаа 4 цагийн сургалт зохион байгуулсан.

Дөрөв: Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

- Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээ:

4.1. Монгол Улсын “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Санхүү эдийн засгийн сайдын 2002 оны “Байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам”, 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн

захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаагийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон журнал, ерөнхий дэвтэрийг бүрэн хөтөлж, бараа материалын тайлан, үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл, бусад тайланг сар, улирал бүр гаргаж, даргын зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцүүлэн, үр дүнг тооцон, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулан, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох газарт хүргүүлж байна.

Мөн торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог төвийн алба хаагч нар ажлын 3 хоногт, хэсгийн төлөөлөгч цагдаа нар 14 хоногт багтааж санхүүтэй тооцоо хийж, үнэт цаасны тайланг сар бүр нярваар гаргуулан цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан үр дүнг тооцуулан ажиллаж байна.

Торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог хугацаанд нь хийгээгүй 1 алба хаагчид тус тус албаны шалгалт явуулж, сахилгын арга хэмжээ авсан бөгөөд торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог хугацаандаа хийгээгүй 8 алба хаагчийн сарын үндсэн цалинг интервалаар 5-20 хувь бууруулав.

Торгуулийн тооцоог хугацаандаа төлөөгүй 24 иргэний материалыг шүүхэд хүргүүлж, шийдвэр гаргуулсан.

Цагдаагийн ерөнхий газраас ирсэн бараа материал болон систем хооронд тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллаж байна.

2017 онд төсөв хэтрүүлсэн асуудал гараагүй.

Тус Цагдаагийн газрын Улаанхус сум дахь цагдаагийн кабоны урсгал засварт ЦЕГ-аас 7.391.500 /Долоон сая гурван зуун ерөн нэгэн мянга таван зуун / төгрөг шийдвэрлэж өгсөн.

Цагдаагийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/24 дүгээр тушаалаар Улаанхус сумын хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ны засварын ажлыг шууд гэрээгээр гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах, засварын ажилд хяналт тавих, хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсэг урсгал засварын ажлыг гүйцэтгүүлэхээр “Шындаулет” ХХК-тай 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр шууд гэрээ байгуулан урсгал засварын ажлыг гүйцэтгүүлсэн.

- Шилэн дансны ил тод байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

4.2. Цагдаагийн газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн 217 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын шилэн дансны мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт өдөр тутам байршуулах үүрэг бүхий албан тушаалтнуудыг томилон ажиллуулж байна.

Шилэн дансны тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Цагдаагийн газрын bayan-ulgii.police.gov.mn цахим хуудас нь “Шилэн данс” гэсэн бие даасан цэс үүсгэн, Монгол Улсын засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.1-д зааснаар төсөв/санхүү, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, Сангийн яамны мэдээлэл, байгууллага, тодруулга өгөх албан тушаалтан гэсэн дэд цэсүүдтэй бөгөөд Шилэн дансны тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг shilendans.gov.mn болон bayan-ulgii.police.gov.mn цахим хуудсанд тогтоосон хугацаанд байршуулав.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

- Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр:

5.1. Тус Цагдаагийн газрын эзэмшилд 2 албаны байртай бөгөөд 2016 онд Монгол Улсад цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 95 жилийн ойг угтаж, цагдаагийн алба хаагч нарын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор тус Цагдаагийн газраас санаачлан “Көшелик” ХХК-тай хамтран цагдаагийн алба хаагч нарын 40 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлсэн.

Эхний ээлжинд 20 айлын орон сууцыг ашиглалтанд оруулж, нээлтийн ажиллагааг 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хийсэн.

“Көшелик” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тус компанийн зүгээс 2 байрыг үнэ төлбөргүй Цагдаагийн газарт шилжүүлэн авсан.

Үлдсэн 20 айлын орон сууц барих ажлыг гэрээний дагуу 2017 оны 05 дугаар сард эхлүүлээд байна.

Цагдаагийн газрын алба хаагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дундын санг аривжуулах, алба хаагч нарт үзүүлэх тусламжийг оновчтой болгох зорилгоор 2016 онд дундын сангийн хөрөнгөнөөс 100 төллөх хонь худалдан авч, малчинд хөлс өгөн маллуулсан бөгөөд 2017 онд төллөж 170 хоньтой болсон.

Хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын ажиллах амьдрах нөхцлийг сайжруулах ажилд сум орон нутгийн удирдлагын дэмжлэг, туслалцаа авах зорилгоор Цагдаагийн газрын дарга, сумын засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарын хамтарсан “Гурвалсан гэрээ” байгуулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан биелэлтийг нь тооцон ажиллаж байна.

“Гурвалсан гэрээ”-д сумын Засаг даргын үүрэг хэсэгт “Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын гэр бүлийн гишүүдийг ажилтай болгох”, “Цагдаагийн кобаны галчийн ажлын хөлс, холбоо, цахилгааны зардлыг орон нутгаас шийдвэрлэх” гэх заалтыг тусгаж өгсөн.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 9 дүгээр сард шашны сайн дурын байгууллагатай хамтран цагдаагийн 67 алба хаагчид хонины 67 ширхэг гулууз мах үнэгүй олгосон.

Цагдаагийн газрын зарим тасаг, хэсгийн алба хаагч нарыг багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олонч сэтгэхүй, нөхөрсөг харилцааг дээшлүүлэх, чөлөөт цагийг нь зөв зохистой өнгөрүүлэх, амраах зорилгоор Сагсай, Цэнгэл, Улаанхус сумын байгалийн үзэсгэлэнт газруудаар 2-7 хоногоор аялуулсан.

ЦЕГ-ын даргын 2015 оны А/25 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын 111.4.11-д “Алба хаагч үр дүнгийн гэрээнийхээ биелэлтийг улирал тутам төсвийн шууд захирагч, эсхүл менежерт батлагдсан маягтын дагуу албан ёсоор мэдээлж байна. Уг мэдээллийг үндэслэн төсвийн шууд захирагч, эсхүл менежер шаардлагатай гэж үзвэл алба хаагчийн гэрээний биелэлтэд хагас жил, эхний есөн сарын байдлаар хяналт-шинжилгээ хийж болно” гэсний дагуу алба хаагч нарын үр дүнгийн гэрээг дүгнэсэн.

Цагдаагийн газрын алба хаагч нартай 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэхэд 8 алба хаагч А, 96 алба хаагч В, 31 алба хаагч С, 8 алба хаагч D үнэлэгдсэн байна.

Мөн алба хаагч нарын ажлыг сар бүр дүгнэн ажлын үр дүн сайтай ажилласан, ажлын байрны зорилго, зорилтоо биелүүлсэн давхардсан тоогоор 108 алба хаагчийн сарын үндсэн цалинг интервалаар 5-20 хувь нэмж, ажлын үр дүн хангалтгүй

ажилласан, ажлын байрны зорилго, зорилтоо биелүүлээгүй давхардсан тоогоор 33 алба хаагчийн сарын үндсэн цалинг интервалаар 5-20 хувь бууруулав.

- Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

5.2. Тус Цагдаагийн газрын алба хаагчдын дунд биеийн тамир спортыг сурталчлах, тэдний хөдөлгөөний болон биеийн тамир спортоор хичээллэх идэвхийг өрнүүлэх, бие бялдар, оюун санааг хөгжүүлэх, эрүүл мэнд, ажлын эрч хүч, багаар ажиллах, хамт олонч сэтгэхүй, нөхөрсөг харилцааг бий болгож, чөлөөт цагийг нь зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор аймгийн Биеийн тамир, спортын газартай гэрээ байгуулан долоо хоногийн “Лхагва” гараг бүрт алба хаагчдыг нэгдсэн журмаар тус газрын биеийн тамирын зааланд цуглуулан биеийн тамирын дасгал сургуулилт хийлгүүлэх, спортын дуртай төрлөөр нь хичээллэх боломжоор хангаж өгсөн.

Мөн “Бялдаржуулах өрөө” нээн ажиллуулж байна.

Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, биеийн тамираар хичээллэх урам, сэдлийг төрүүлэх, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн газрын даргын тушаалаар “Биеийн тамир спорт хамтлаг”-ийг шинээр байгуулсан. Тухайн хамтлаг нь тасаг, албадууд болон сэтгэл зүйчтэй хамтран бие бүрэлдэхүүний дунд өдөр болгон гимнастик хийлгэх ажлыг хэвшүүлсэн ба 2017 онд алба хаагчдын дунд 6 төрлийн биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулсан.

Тус Цагдаагийн газрын алба хаагч нарыг жилд нэг удаа үнэ төлбөргүй нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг ажлыг аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгуулаад 3 жил болж байна.

- Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ:

5.3. Тус цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгээс 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт бие бүрэлдэхүүнд сургалтын материал бэлтгэж, 2017 оны 04 дүгээр сарын 05-наас 04 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан нэгдүгээр улирлын сургалтаар орон тооны бус ажлын хэсгийн гишүүн ТЗБТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Ганбат “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар, МХГХТХэсгийн дарга, цагдаагийн хошууч Б.Хайырлыс “Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал”, хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Дэнсмаа “Авилгын эсрэг хууль тогтоомж”, холбоо мэдээллийн инженер, цагдаагийн ахмад Т.Ардакелди “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” зэрэг сэдвүүдээр 4 цагийн сургалтыг зохион явуулав.

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сонор сэрэмжийг дээшлүүлэх талаар орон тооны бус ажлын хэсгээс улирал бүр тодорхой хэмжээний ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын талаар Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж байна. Үүнд:

2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр дотоод хяналтаар хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Т.Еркетай захиргааны арга хэмжээ авсан материалыг гээгдүүлсэн гэх мэдээллийг үндэслэн хэрэг бүртгэх эрхтэй алба хаагч нараас захиргааны арга хэмжээ авсан материалыг хуулийн хүрээнд явуулсан эсэхийг шалгах зорилгоор 2016 он болон 2017 оны эхний 5 сарын байдлаар захиргааны бүх материалд хяналт шалгалт явуулах ажлыг хэсгийг Цагдаагийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/22 дугаартай тушаалаартомилж, шалгалт явуулав.

Шалгалтаар нийт 8 алба хаагчид холбоотой 22 төрлийн зөрчил илэрч, цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 15 материалыг

архивт хүлээлгэж өгөөгүй хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Т.Еркетайд сарын үндсэн цалинг 3 сар 20 хувь хасах сахилгын шийтгэл оногдуулж, бусад алба хаагч нарын гаргасан зөрчлийг засуулж, цаашид энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар зөвлөлийн хурлын тэмдэглэлээр анхааруулав.

Мөн алба хаагч нарын аюулгүй байдлыг хангах үүднээс өдөр бүр томилогдсон ес журмын эргүүлүүд алба хаагч нарт амаар үүрэг, даалгавар өгөх асуудлыг таслан зогсоож эргүүл, харуулуудыг шалгахдаа заавал бичгээр үүрэг, чиглэл өгөх ажлыг хэвшил болгож, урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна.

Ёс журмын эргүүлийн илрүүлсэн зөрчлийг сар бүр Цагдаагийн газрын дэргэдэх зөвлөлийн хурлаар авч хэлэлцэж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагч нарт холбогдох, хууль, журмын дагуу хариуцлага тооцон ажиллаж байна.

Цагдаагийн газрын орон тооны бус ажлын хэсгээс дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2017 онд нийт 10 удаа хуралдсан.

Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газрын төв байрны аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий 9 ширхэг аналог хяналтын камерын ашиглалтын хугацаа дуусч, орчноо бүрэн хянах боломжгүй болсон талаар Цагдаагийн газрын дотоод хяналт шалгалт аюулгүй байдал хариуцсан орон тооны бус ажлын хэсэг, ЦГ-ын удирдлагад танилцуулан Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийн 2017 оны төлөвлөгөөнд тусгуулан 4 640 000 төгрөг шийдвэрлүүлж, тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “Нур-Ернур” ХХК-тай хяналтын камер нийлүүлэх гэрээ байгуулан Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага MNS 6423:2013 стандартыг хангасан 16 ширхэг тоон технологийн хяналтын камер, бусад шаардлагатай техник хэрэгсэл худалдан авч, төв байрнд 8 хяналтын камер, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий алба хаагчдын өрөөнд 8 ширхэг тоон технологийн хяналтын камер нэмж суурилуулсан.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

- Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байдал:

6.1. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 842 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний /код 110/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 4/785 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Байгууллагын жилийн үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тайлагнах зааварчлага”-ын дагуу Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд 2017 оны үйл ажиллагаанд хагас жилээр хяналт шинжилгээ хийсэн.

2017 ил алаа хэсэг, алаа хаагч нарын аюулгүй байдлыг хангах үүрэг, даалгавар өгөх асуудлыг таслан зогсоож эргүүл, харуулуудыг шалгахдаа заавал бичгээр үүрэг, чиглэл өгөх ажлыг хэвшил болгож, урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна.

Орчноо бүрэн хянах боломжгүй болсон талаар Цагдаагийн газрын дотоод хяналт шалгалт аюулгүй байдал хариуцсан орон тооны бус ажлын хэсэг, ЦГ-ын удирдлагад танилцуулан Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийн 2017 оны төлөвлөгөөнд тусгуулан 4 640 000 төгрөг шийдвэрлүүлж, тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “Нур-Ернур” ХХК-тай хяналтын камер нийлүүлэх гэрээ байгуулан Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага MNS 6423:2013 стандартыг хангасан 16 ширхэг тоон технологийн хяналтын камер, бусад шаардлагатай техник хэрэгсэл худалдан авч, төв байрнд 8 хяналтын камер, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий алба хаагчдын өрөөнд 8 ширхэг тоон технологийн хяналтын камер нэмж суурилуулсан.

- Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар:

6.2. Тус Цагдаагийн газар нь 2017 онд Цагдаагийн байгууллагын зорилго, зорилтуудыг хангахад учирч болох /саад тогтор, эсхүл илүү боломж буюу ердийн үйл

ажиллагааг явуулахад хүргэдэг хэвийн бус хохирол, үр дагавар/ эрсдэлийг Хууль зүйн сайдын 2013 оны А/248 тоот тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдэлийг үнэлэх аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам /код 137/-ын дагуу эрсдэлийг тооцон, эрсдэлийг сааруулах зорилгоор хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Мөн төсөв санхүүгийн, үйл ажиллагааны, нийцлийн буюу эрх зүй, зохицуулалтын эрсдэл, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрсдлээс байгууллагын эрсдийг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр гарсан эрсдэлүүдийг жагсаан үйл ажиллагааны явцад гарч болохуйц болзошгүй ямар эрсдэл байгааг тооцож, үйл ажиллагааны явцад гарч болзошгүй тул тэдгээрийн давтамж, цар хүрээг нягтлан шинжилж, эрсдэл гаруулахгүй байх талаас нь удирдлагын хяналтыг чиглүүлж, үр дүнд тухай бүр тооцон ажиллав.

- Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар:

6.3. Хууль зүйн сайдын 2015 оны А/238 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг нийт алба хаагч нарт танилцуулж, журмын 6 дугаар зүйлийн 6.1-д “Албаны шалгалтыг цагдаагийн төв байгууллагын удирдлага, харъяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналт шалгалт хариуцсан нэгж, даалгасан алба хаагч /тасаг, хэсгийн дарга буюу түүнээс дээш албан тушаалтан хамаарна/ биечлэн журмын хавсралт 1-д заасан харьяаллын дагуу явуулна” гэж заасан тул алба хаагч нарт албаны шалгалт явуулах асуудлаар тус Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарт хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Ганбат 1 цагийн сургалт зохион явуулсан.

Тус Цагдаагийн газрын эрх бүхий алба хаагч нар 2017 онд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол, хүсэлт болон дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн 31 зөрчилд холбогдох 43 алба хаагчид албаны шалгалт явуулж, 27 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, 16 зөрчилд албаны шалгалт явуулахад сахилга ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй байна.

Дотоод хяналтаар 13 алба хаагчид албаны шалгалт явуулсан бол иргэд, байгууллагын мэдээллээр 30 алба хаагчид албаны шалгалт явуулсан.

ЦАГДААГИЙН ГАЗАР